- ✓ Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 71 дүгээр тушаалаар “Ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан;
- ✓ Хэмжил зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 250 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж батлуулсан;
- ✓ Стандарт, хэмжил зүйн газрын 1-р байрны Их засварын үед мөрдөх түр журмын төсөл боловсруулж, холбогдох нэгжийн дарга нараас санал авч, хянуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/138 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс мөрдөн ажиллаж байгаа;
- ✓ Стандарт, хэмжил зүйн газрын даргын Зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар “Хэмжих хэрэгслийн загварыг турших журам”, “Хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийх журам”-ыг шинэчлэн батлуулахаар хянасан. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн шийдвэрээр дээрх журмуудыг шинэчлэн батлуулах, холбогдох байгууллагуудад бүртгүүлэхээр шийдвэрлэсэн;
- ✓ “Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын төслийг боловсруулж, батлуулахаар зохион байгуулалтын нэгжийн дарга нараас саналыг авч нэгтгэн даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажилласан байна.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 10 дугээр сарын 31-ний өдрийн А/296 дугаар тушаал, удирдамжаар аппаратын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэн, илэрсэн алдаа зөрчилд зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллассан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2024 онд баталсан бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлоготой холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусгаагүй, бэлэн бүтээгдэхүүний дансанд үнэт цааснуудыг, бусад үндсэн хөрөнгийн бүртгэлд сорьцын баталгаажуулалтын хэрэгсэл буюу бараа материалын шинж чанартай зүйлсийг бүртгэдэг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Стандарт, хэмжил зүйн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,352,452.8 мянган төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 30,521.3 | 302,405.0 | 271,883.7 |
| Авлага | 664,527.0 | 5,626,878.5 | 4,962,351.5 |
| Урьдчилгаа | 716,367.5 | - | (716,367.5) |
| Бараа материал | 767,144.7 | 745,288.6 | (21,856.1) |
| Үндсэн хөрөнгө | 5,623,997.3 | 9,480,438.5 | 3,856,441.2 |
| Нийт хөрөнгө | 7,802,557.8 | 16,155,010.6 | 8,352,452.8 |
| Өглөг | 47,150.2 | 643,117.9 | 595,967.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 7,755,407.6 | 15,512,464.7 | 7,757,057.1 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 7,802,557.8 | 16,155,010.6 | 8,352,452.8 |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 271,883.7 мянган төгрөгт болж нэмэгдсэн нь барьцаа хөрөнгийн данс нээж гүйцэтгэлийн баталгааг байршуулсантай холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 5,626,878.5 мянган төгрөг болж өссөн нь татаас санхүүжилтийн авлага 5,552,878.5 мянган төгрөгөөр, сорил хэмжилт, баталгаажуулалт

болон бусад төлбөрт үйлчилгээний авлага 74,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

- Урьдчилгаа дансны үлдэгдэл 716,365.5 мянган төгрөгөөр буурсан нь "Говь хангай Буйдан" ХХК-аас авах 604,220.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг үндсэн хөрөнгийн дансанд орлогодсон. Мөн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулж 93,147.5 мянган төгрөгийг зардлаар, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хийлгэж 19,000.0 мянган төгрөгийг бараа материал дансанд тайлагнасантай холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 745,288.6 мянган төгрөг болж, 21,856.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,157,232.8 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 1,513.8 мянга төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, өмнөх бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж төлсөн зардлаас 19,000.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг орлогодож, үйл ажиллагаандаа 320,638.4 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 2,817,515.9 мянган төгрөгийн материалыг харьяа байгууллагуудад шилжүүлэн, Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2025 оны А/51, А/273 дугаар тушаалаар 39,592.3 мянган төгрөгийн материалыг акталсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 9,480,438.5 мянган төгрөг болж, 3,856,441.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь:
  - ✓ Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,360,560.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүйгээр 440,634.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан;
  - ✓ Өмнөх онд бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж төлсөн зардлаас 604,220.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг, авлагаас 17,600.0 мянган төгрөгийн эталон цагийн дэлгэцийг хүлээн авч бүртгэсэн;
  - ✓ Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд байрлалтай сорьцын шинжилгээний барилгын газар эзэмших эрхийг 289,600.0 мянган төгрөгөөр үнэлүүлж бүртгэсэн;
  - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 585 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,301,333.4 мянган төгрөгийн хөрөнгийг 473,836.5 мянган төгрөгөөр үнэ шинэчлэн бүртгэсэн;
  - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А/2105 албан бичгийн дагуу 63,347.7 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг харьяа байгууллагуудад шилжүүлсэн;
  - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 454 дүгээр тогтоолоор 69,335.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг акталж данснаас хассан;
  - ✓ Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн 1,266,661.6 мянган төгрөгийн элэгдлийг байгуулсан зэргэтэй холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 643,117.9 мянган төгрөг болж, 595,967.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 302,405.0 мянган төгрөгийн чанарын баталгааг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж өглөгөөр тайлагнасантай, мөн албан хаагчдад өгөх гадаад томилолтын 34,943.9 мянган төгрөгийн, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын 258,618.8 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 15,512,464.7 мянган төгрөг болж, тайлант оны санхүүгийн үр дүнгийн өөрчлөлтөөр 7,757,057.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 508,883.9 мянган төгрөгийн үнэ бүхий 7 программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Үүнээс тайлант онд төсвийн хөрөнгөөр нийт 489,100.0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 программыг сайжруулалт хийсэн. Үүнд:

- ✓ Бүтээгдэхүүн,үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын программ 199,500.0 мянган төгрөг;
- ✓ Хэмжил зүйн мэдээллийн сангийн программ хөгжүүлэхэд 289,600.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

## 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2025 оны төсвийн төсөлд нийт урсгал үйл ажиллагааны зарлагыг 12,490,753.0 мянган төгрөгөөр төсөвлөн, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,833,453.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,650,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 7,300.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлэхээр тооцон, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас урсгал үйл ажиллагааны зардлыг 1,558,029.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогыг 682,827.9 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогыг 7,300.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 10,242,596.1 мянган төгрөгөөр баталсан нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон эд хогшил, урсгалд засварын зардлыг хасаж баталсантай холбоотой.

Монгол Улсын 2025 оны төсөвт 1 удаа тодотгол хийж төсвийн урсгал үйл ажиллагааны зардлыг 494,444.3 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 916,400.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан тодотгож, үйл ажиллагааны орлогыг 334,825.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан.

Тайлант онд Төсвийн тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 42 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч Стандарт, хэмжил зүйн газрын 2025 онд батлагдсан төсвөөс 5 удаа төсвийн зохицуулалт хийж урсгал үйл ажиллагааны зардлыг 9,306,832.7 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 10,483,200.0 мянган төгрөгөөр тооцож, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 14,559,323.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,230,709.7 мянган төгрөгөөр баталсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 14,559,323.0 төгрөгийг улсын төсвөөс, 5,230,709.7 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,263,313.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 10,954,145.3 мянган төгрөг, нийт 25,217,458.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 19,113,443.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 6,104,015.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 19,113,443.2 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 319,412.2 мянган төгрөгөөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 220,051.1 мянган төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлыг 65,428.4 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 2,001.0 мянган төгрөгөөр, лабораторийн итгэмжлэлийн зардлыг 57,899.1 мянган төгрөгөөр, олон улсын гишүүнчлэлийн хураамжийн зардлыг 9,242.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 1,867.4 мянган төгрөгөөр, бусад хөрөнгө оруулалтын зардлыг 687.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт /хувь/ |
|---|---|---|---|---|---|
| 70407 | Стандартчилал, хэмжил зүй | 19,790,032.7 | 19,113,443.2 | 676,589.5 | 96.6 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 8,404,886.9 | 8,085,474.7 | 319,412.2 | 96.2 |
| 80205 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 10,972.5 | 10,972.5 | - | 100.0 |
| 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил | 274,963.3 | 54,912.2 | 220,051.1 | 20.0 |
| 80224 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 73,630.9 | 8,202.5 | 65,428.4 | 11.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 80219 | Харуул хамгаалалтын зардал | 74,000.0 | 71,999.0 | 2,001.0 | 97.3 |
| 80227 | Лабораторийн итгэмжлэл | 66,600.0 | 8,700.9 | 57,899.1 | 13.1 |
| 80509 | Олон байгууллагын гишүүнчлэлийн хураамж | 246,000.9 | 236,758.3 | 9,242.6 | 96.2 |
| 80802 | Ажил, олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал | 155,778.2 | 153,910.8 | 1,867.4 | 98.8 |
| 80918 | Бусад | 10,483,200.0 | 10,482,512.3 | 687.7 | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Стандарт, хэмжил зүйн газрын орон тооны хязгаарыг 199 орон тоогоор батлалснаас 19 бууруулж 181 байхаар тогтоосны дагуу Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 10 дугаар сарын 08-ний өдрийн 158 тушаалаар Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталжээ. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/188 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн баталсан;
2. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/12 дугаар тушаалаар алба хаагчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 24.0 мянган төгрөгөөр, унааны төлбөрийг 1.0 мянган төгрөгөөр баталсан. Тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 921,373.0 мянган төгрөгийг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 1,006,466.6 мянган төгрөгийг зарцуулж, 85,093.6 мянган төгрөгийг хэтрүүлсэн байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой;
3. Гадаад зочин хүлээн авах арга хэмжээний зардалд 2,790.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 1,300.0 мянган төгрөг зарцуулсан. Гадаад томилолтын зардалд 72,178.7 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 63,425.3 мянган төгрөгийг олон улсын гишүүнчлэлийн сургалт семинарын зардалд зарцуулсан байна. Гадаад томилолтын 24,543.9 мянган төгрөгийн өглөг тайлагнасан нь зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хянаж зарцуулахгүй байгааг харуулж байна;
4. Тайлант хугацаанд хичээл, үйлдвэрлэлийн зардалд 68,806.2 мянган төгрөгийг төсөвлөж, гүйцэтгэлээр 54,998.0 мянган төгрөгийг зарцуулсан. Стандарт ба эрх зүйн орчин сургалт, семинарын зардалд 40,600.0 мянган төгрөг, төр, хувийн хэвшил мэргэжлийн холбоодын дунд стандартын хэрэгжилт ба эрх зүйн орчны хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн хэлэлцүүлэг 1,776.0 мянган төгрөг, удирдах ажилтны зөвлөгөөнд 12,622.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан;
5. Стандартчиллыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэх ажлын хүрээнд 1 хуулийн этгээдтэй 10,972.5 мянган төгрөгийн гэрээ байгуулж санхүүжүүлсэн;
6. Стандарт, хэмжил зүйн газарт төрд учирсан хохирлыг барагдуулах зардал гараагүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд онд нэмэлт санхүүжилтийн дансаар татаас санхүүжилтийн авлага 13,870.0 мянган төгрөг, төсвийн дээд шатны захирагчаас 5,000.0 мянган төгрөгийн, нийт 18,870.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 17,000.0 мянган төгрөгийг зарцуулан, 1,870.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/235 дугаар тушаалаар өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Шадар сайдын багцад тусгагдсан Стандарт хэмжил зүйн газраас 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 19 багцын хүрээнд 10,483,050.4 мянган төгрөгөөр баталж, Төрийн худалдан авах ажиллагааны газарт эрх шилжүүлэн зохион байгуулжээ.

Тус газрын худалдах авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1.Тайлант хугацаанд байрны харуул, хамгаалалтын зардалд 71,751.0 мянган төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Байрны харуул хамгаалалтын ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт, хэмжил зүйн ерөнхий газрын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Стандарт, хэмжил зүйн газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бужинханд, аудитор С.Болортуяа нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/94 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын сууриар 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 14,671,280.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 146,712.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 5,805,981.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 255,833.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг хүргүүлж, 5,550,147.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд байршуулбал зохих зарим мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал:

- ✓ Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт- 1 удаа;

- ✓ Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал -1 удаа;
- ✓ Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт-1 удаа;
- ✓ Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан-1 удаа;
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний нийт 14,048.6 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцроосон.
- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын мөнгөн гүйлгээний нийт 170,033.9 мянган төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн байршуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны “ар шижир”-т байршилтай 50,000 $м^2$ зуслангийн зориулалттай газрыг гэрчилгээгээр /000324031 нэгж талбарын дугаартай, 2018 онд 15 жилийн эзэмших эрхээр олгосон/ Стандарт, хэмжил зүйн газар эзэмшиж байгаа боловч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж тодруулах арга хэмжээ авч, цаашид үндсэн хөрөнгөд бүртгэх эсэх талаар шийдвэрлэх зөвлөмж өгсөн.

2. Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Стандарт, хэмжил зүйн газрын орон тооны хязгаарыг 199 орон тоогоор баталснаас 19 бууруулж 181 байхаар тогтоосны дагуу Монгол Улсын шадар сайдын 2025 оны 10 сарын 8-ний өдрийн 158 тушаалаар Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/188 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоо шинэчлэн баталсан ч албан хаагчдыг бүтэц, албан тушаалын ангиллын дагуу ажиллуулаагүй байна.

Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлээр цалин хөлсний зардал нь нийт бүлгийн дүнгээр хэтрээгүй ч зардлын эдийн засгийн ангиллаар үндсэн цалин 14,493.2 мянган төгрөг, нэмэгдэл 10,719.9 мянган төгрөг, унаа хоолны хөнгөлөлт 85,093.6 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан байгаа нь төсвийн төлөвлөлтийг алдаатай боловсруулсантай холбоотой байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.3.-т батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;", 16.5.9-д "дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Албан хаагчдыг батлагдсан бүтэц, албан тушаалын ангиллын дагуу ажиллуулах зохион байгуулалтыг хийж, цалингийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах талаар зөвлөмж өгсөн.

3. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх онуудын гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй. Тухайлбал: 2024 онд 2,250,142.1 мянган төгрөг, 2025 онд 5,550,147.9 мянган төгрөгийн орлого тус тус давж биелсэн байна.

Энэ нь А/282 дугаар тушаалын хавсралт "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.2-т "Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгагдахгүй орхигдуулах" 3.6-т энэ журмын 3.1.1-д заасан орлогын сүүлийн гурван жилийн гүйцэтгэл болон 3.1.2-т заасан орлогын үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн төлөвлөгөөг нэмэгдүүлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Орлогын төлөвлөгөөг бодитой тооцож, үйлчилгээний үнэ, тарифын нэмэгдэл, өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулан, үйл ажиллагаанд нөлөөлөх бусад гадаад дотоод орчны нөлөө зэргийг харгалзан үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг хангах талаар зөвлөмж өгсөн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 659,585.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 236,529.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулан, 423,056.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 8 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Стандарт, хэмжил зүйн газрын бүтэц, орон тоо 199 байсныг 181 болгож шинэчлэн баталсан;
- Үндсэн үйл ажиллагааны 22,830.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснийг залруулж үндсэн дансанд шилжүүлсэн;
- "УБЦТС" ТӨХК-аас он дамнасан 370,969.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан;
- Хуулийн этгээдтэй 4,111.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулсан.
- Хэмжил, зүйн зөвлөлийн гишүүдэд олгосон 5,755.0 мянган төгрөгийн, ажил олгогчоос олгосон 5,022.0 мянган төгрөгийн шагнал, урамшууллыг татварын тайланд тайлагнасан;

- Албан хаагчдад 4,653.4 мянган төгрөгийн албан томилолтыг илүү олгосныг ажилчдаас суутгаж зөрчлийг арилгасан байна.

Завсрын аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй асуудалд холбогдох шийдвэрийг өгсөн.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 12,003.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 1,976,360.7 мянган төгрөгийн зөрчил арилгах 8 албан шаардлага хүргүүлснээс 1,962,067.9 мянган төгрөгийн 7 албан шаардлагыг, 18,672,067.9 мянган төгрөгийн 9 зөвлөмж өгснийг тус тус бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 4 | 12,003.1 | 4 | 12,003.1 | 100.0 |
| Албан шаардлага | 8 | 1,976,360,7 | 7 | 1,962,785,.7 | 99.3 |
| Зөвлөмж | 9 | 18,672,067.9 | 9 | 18,672,067.9 | 100.0 |
| Нийт дүн | 21 | 20,660,431.7 | 20 | 20,646,856.7 | 99.8 |

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн шийдвэрээс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 15,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашины хохирлыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ асуудлаар Стандарт, хэмжил зүйн газар нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2025 оны 01 дүгээр сарын 31-ны 01/161 дугаар албан бичгээр нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэлийн дагуу 2025 оны 9 сард шүүх хурал зарлагдсан боловч байгууллагын төлөөлөл болсон албан хаагч ээлжийн амралттай байсан шалтгаанаар хурал хойшлогдож, 2025 оны 10 сард дахин зарласан боловч шүүх бүрэлдэхүүн цуцлагдаж хойшлогдсон, 2026 онд шүүх хурал дахин товлогдсон байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орлогын төлөвлөлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,045,039.4 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 23,181,191.2 мянган төгрөгийн 11 алдааг залруулж, 2,863,848.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулах албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

***Залруулсан алдаа:***

1. Санхүүгийн байдлын тайланд 1,029,763.3 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгслийг зам, гүүрний байгууламж /39209/ ангиллаар тайлагнасан;
2. Үр дүнгийн тайланд “Петростар” ХХК-аас мөнгөөр олгосон 651.3 мянган төгрөгийн урамшууллыг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал дансаар бүртгэсэн;
3. Мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10,482,512.2 мянган төгрөгийн санхүүжилтийг 131003 буюу төвлөрүүлэх шилжүүлэг дансны ангиллаар тайлагнасан;
4. Түрээсийн барьцаанд урьдчилж байршуулсан 1,100.0 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор тайлагнаагүй;
5. Мөнгөн гүйлгээний тайланд тайлант хугацааны эцэст улсын төсөвт үндсэн данснаас төвлөрүүлсэн 6,104,345.1 мянган төгрөгийг, нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 1,870.0 мянган төгрөг, ахмадын сангийн данснаас төвлөрүүлсэн 721.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох төвлөрүүлэх шилжүүлэг дансаар тайлагнасан;
6. Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний зөрүүг 732,863.7 мянган төгрөгөөр тайлагнасан боловч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд хөрөнгө тус бүрээр дахин үнэлгээний зөрүүг тайлагнаагүй;
7. Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлого, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг 13,310.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
8. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 289,600.0 мянган төгрөгийн программыг бусад ангиллаар тайлагнасан;
9. Үр дүнгийн тайланд улсын төсвийн хөрөнгө, оруулалтын санхүүжилтийг 4,353,761.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
10. Үр дүнгийн тайлангийн зардлын ангиллыг 13,742.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
11. Татаас санхүүжилтийн авлагыг 156,950.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон аудитын "Оршин байх”, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Залруулаагүй алдаа:***

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,863,848.2 мянган төгрөгийн барилгын их засварын ажлыг хүлээн авсан ч өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, газрын даргын тушаал гараагүй тул хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл суурь дээр хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-т "бүх орлого", 14.4.6-д "бүх

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зардал", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-тай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилгын их засварыг үндсэн хөрөнгийн дансанд капиталжуулж бүртгээгүй алдааг залруулах албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 652,700.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 652,700.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,516,548.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,369,836.0 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг "Дижитал медик" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулаагүйгээр мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээний хураамжийн нийт 228,488.6 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг уг аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байх үр дагавартайгаас гадна байгууллага хооронд үүсэх харилцаа, маргааныг зохицуулах боломжгүй нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.39-т "төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч" гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг;", 41 дүгээр зүйлийн 41.2.-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлсэн зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл болон илтгэх хуудаст программ хангамжийн дүнг 289,000.0 мянган төгрөгөөр, бараа материалын дүнг 17,792.9 мянган төгрөгөөр санхүүгийн тайлангийн дүнгээс тус тус зөрүүтэй тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т ”Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6.-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүнг тайлангийн дүнгээс зөрүүтэй тусгасан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/93 дугаар тушаалаар "Стандарт, хэмжил зүйн газрын албан хаагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих арга хэмжээ"-г зохион байгуулж, нийт 9,715.2 мянган төгрөгөөр байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах:", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

4.Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт 72,760.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, оны эцэст авлагатай гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 6.4.8.-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Үндсэн үйл ажиллагааны орлогын авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, оны эцэст авлагатай гарсан зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

5.Тайлант онд гадаад томилолтын зардалд 21,173.3 мянган төгрөг, Олон улсын чуулга уулзалтын бүртгэлийн хураамжид 10,400.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 3,370.0 мянган төгрөг, нийт 34,943.9 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, санхүүгийн тайланд өр төлбөртэй гарсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 6.4.8.-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулдаг, өр үүсгэсэн зөрчлийг таслан таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайланд 1,029,763.4 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгслийг зам, гүүрний байгууламж /39209/ ангиллаар тайлагнасан. | 1 | 1,029,763.3 | - | - | 1 | 1,029,763.3 | 1 | 1,029,763.3 | - | - | - | - |
| Үр дүнгийн тайланд “Петростар” ХХК-аас мөнгөөр олгосон 651.3 мянган төгрөгийн урамшууллыг үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал дансаар бүртгэсэн. | 1 | 651.3 | - | - | 1 | 651.3 | 1 | 651.3 | - | - | - | - |
| Мөнгөн гүйлгээний тайланд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10,482,512.3 мянган төгрөгийн санхүүжилтийг 131003 буюу төвлөрүүлэх шилжүүлэг дансны ангиллаар тайлагнасан. | 1 | 10,482,512.2 | - | - | 1 | 10,482,512.2 | 1 | 10,482,512.2 | | | | |
| Түрээсийн барьцаанд урьдчилж байршуулсан 1,100.0 мянган төгрөгийг урьдчилж орсон орлогоор тайлагнаагүй. | 1 | 1,100.0 | - | - | 1 | 1,100.0 | 1 | 1,100.0 | - | - | - | - |
| Мөнгөн гүйлгээний тайланд тайлант хугацааны эцэст улсын төсөвт үндсэн данснаас төвлөрүүлсэн 6,104,345.0 мянган төгрөгийг, нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 1,870.0 мянган төгрөг, Ахмадын данснаас төвлөрүүлсэн 721.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох төвлөрүүлэх шилжүүлэг /213403/ дансаар тайлагнасан. | 1 | 6,106,936.3 | - | - | 1 | 6,106,936.3 | 1 | 6,106,936.3 | - | - | - | - |
| Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний зөрүүг 732,863.7 мянган төгрөгөөр тайлагнасан боловч үндсэн | 1 | 732,863.7 | - | - | 1 | 732,863.7 | 1 | 732,863.7 | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд хөрөнгө тус бүрээр дахин үнэлгээний зөрүүг тайлагнаагүй байна. | | | | | | | | | | | | |
| Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн орлого, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг 13,310.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 13,310.0 | - | - | 1 | 13,310.0 | 1 | 13,310.0 | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 289,600.0 мянган төгрөгийн программыг бусад ангиллаар тайлагнасан | 1 | 289,600.0 | - | - | 1 | 289,600.0 | 1 | 289,600.0 | - | - | - | - |
| Үр дүнгийн тайланд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 4,353,761.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 4,353,761.1 | - | - | 1 | 4,353,761.1 | 1 | 4,353,761.1 | - | - | - | - |
| Үр дүнгийн тайлангийн зардлын ангиллыг 13,742.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан/ гадаад томилолтын зардал мөнгөн гүйлгээний тайлантай зөрүүтэй тайлагнасан. | 1 | 13,742.2 | - | - | 1 | 13,742.2 | 1 | 13,742.2 | - | - | - | - |
| Татаас санхүүжилтийн авлага тооцоо нийлсэн актаар 156,950,7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 156,950.7 | - | - | 1 | 156,950.7 | 1 | 156,950.7 | | | | |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,863,848.2 мянган төгрөгийн барилгын их засварыг ажлыг хүлээн авсан ч өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, даргын тушаал гараагүйгээс хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй байна. | 1 | 2,863,848.2 | | | | | | | 1 | 2,863,848.2 | 1 | 2,863,848.2 |
| Дүн | 12 | 26,045,039.4 | - | - | 11 | 23,181,191.2 | 11 | 23,181,191.2 | 1 | 2,863,848.2 | 1 | 2,863,848.2 |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг "Дижитал медик" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулаагүйгээр мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээний хураамжийн нийт 228,488.6 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг "Дижитал медик" ХХК-ийн дансаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байх үр дагавартайгаас гадна байгууллага хооронд үүсэх харилцаа, маргааныг зохицуулах боломжгүй байна. | 1 | 228,488.6 | - | - | 1 | 222,488.6 | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл, илтгэх хуудаст тусгасан программ хангамжийн дүн 289,000.0 мянган төгрөгөөр, бараа материалын тайлангаас 17,792.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасан байна. | 1 | 306,792.9 | - | - | 1 | 306,792,9 | - | - | - | - |
| Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/93 дугаар тушаалаар "Стандарт, хэмжил зүйн газрын албан хаагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих арга хэмжээ"-г зохион байгуулж байгууллагын төсвөөс 9,715.2 мянган төгрөгийг зарцуулсан. | 1 | 9,715.2 | - | - | 1 | 9,715.2 | - | - | - | - |
| Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт 72,760.0 мянган төгрөг барагдуулах арга хэмжээ аваагүй, оны эцэст авлагатай гарсан. | 1 | 72,760.0 | - | - | 1 | 72,760.0 | - | - | - | - |
| Батлагдсан төсвөөс хэтрүүлэн албан хаагчдад гадаад томилолтын зардалд 21,173.3 мянган төгрөг, Олон улсын чуулга уулзалтын бүртгэлийн хураамж 10,400.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 3,370.6 мянган төгрөг нийт 34,943.9 мянган төгрөгийг өгөх өглөгтэй гарсан. | 1 | 34,943.9 | - | - | 1 | 34,943.9 | - | - | - | - |
| Дүн | 5 | 652,700.6 | - | - | 5 | 652,700.6 | - | - | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил* | | | | | | | | |
| Шилэн дансны цахим системд байршуулбал зохих зарим мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлсэн байна. Тухайлбал:<br>Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт- 1 удаа; Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал -1 удаа;<br>Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт-1 удаа;<br>Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан-1 удаа; Орлогын 5 сая төгрөгөөс дээш гүйлгээний нийт 14,048.6 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцроосон; Зарлагын 5 сая төгрөгөөс дээш гүйлгээний нийт 170,033.9 мянган төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцроосон байна. | 1 | 184,082.5 | - | - | 1 | 184,082.5 | - | - |
| Дүн | 1 | 184,082.5 | - | - | 1 | 184,082.5 | - | - |
| *Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил* | | | | | | | | |
| "1. Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Стандарт, хэмжил зүйн газрын орон тооны хязгаарыг 199 орон тоогоор баталснаас 19 бууруулж 181 байхаар тогтоосны дагуу Монгол Улсын шадар сайдын 2025 оны 10 сарын 8-ний өдрийн 158 тушаалаар Стандарт, хэмжил зүйн газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/188 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоо шинэчлэн баталсан ч албан хаагчдыг бүтэц, албан тушаалын ангиллын дагуу ажиллуулаагүй байна. 2.Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлээр цалин хөлсний зардал нь нийт бүлгийн дүнгээр хэтрээгүй ч зардлын эдийн засгийн ангиллаар үндсэн цалин 14,493.2 мянган төгрөг, нэмэгдэл 10,719.9 мянган төгрөг, унаа хоолны хөнгөлөлт 85,093.6 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан байгаа нь төсвийн төлөвлөлтийг алдаатай боловсруулсантай холбоотой байна | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Тус байгууллагын нэр дээр 2018 оны 50,000 м2 зуслангийн зориулалттай Сонгинохайрхан дүүргийн ар шижрийн 21 дүгээр хороонд 000324031 тоот 15 жилийн эзэмших эрхтэй газар нь үндсэн хөрөнгийн дансны ангилалд бүртгэлгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант хугацаанд байрны харуул хамгаалалтын зардалд 71,751.0 мянган төгрөгийн үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна. | 1 | 71,751.0 | - | - | 1 | 71,751.0 | - | - |
| Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх онуудын гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй. Тухайлбал: 2024 онд 2,250,142.1 мянган төгрөг, 2025 онд 5,550,147.9 мянган төгрөгийн орлого давж биелсэн байна. | 1 | 5,550,147.9 | - | - | - | - | 1 | 5,550,147.9 |
| Дүн | 4 | 5,621,898.9 | - | - | 1 | 71,751.0 | 3 | 5,550,147.9 |
| НИЙТ ДҮН | 5 | 5,805,981.4 | - | - | 2 | 255,833.5 | 3 | 5,550,147.9 |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 41/А0171320 Улаанбаатар хот

САГ-2026/203/НА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг "Дижитал медик" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулаагүйгээр мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээний хураамжийн нийт 228,488,600.00 (хоёр зуун хорин найман сая дөрвөн зуун наян найман мянга зургаан зуун) төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг уг аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлогын бүрдүүлэлт, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байх үр дагавартайгаас гадна байгууллага хооронд үүсэх харилцаа, маргааныг зохицуулах боломжгүй нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.39-т "төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч" гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг;", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Дижитал медик" ХХК-ийн хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогыг тус аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан байгууллагын дансанд төвлөрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга /Л.Батбаяр/, ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
АХЛАХ АУДИТОР Ж.БҮЖИНХАНД
АУДИТОР С.БОЛОРТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-1.Docx

1526180107

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 42/А0171320 Улаанбаатар хот

САГ-2026/203/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгүүдийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл болон илтгэх хуудаст программ хангамжийн дүнг 289,000,000.00 (хоёр зуун наян есөн сая) төгрөгөөр, бараа материалын дүнг 17,792,900.00 (арван долоон сая долоон зуун ерэн хоёр мянга есөн зуун) төгрөгөөр санхүүгийн тайлангийн дүнгээс тус тус зөрүүтэй тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын "4.2.1.2.-д хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй;гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгүүдийн үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын бүртгэл, илтгэх хуудаст программ хангамж, бараа материалын дүнг зөрүүтэй тусгасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга /Л.Батбаяр/, ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | А.ЦОГБАЯР |
| АХЛАХ АУДИТОР | Ж.БУЖИНХАНД |
| АУДИТОР | С.БОЛОРТУЯА |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 43/А0171320 Улаанбаатар хот

САГ-2026/203/ИА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны А/93 дугаар тушаалаар "Стандарт, хэмжил зүйн газрын албан хаагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих арга хэмжээ"-г зохион байгуулж, нийт 9,715,200.00 (есөн сая долоон зуун арван таван мянга хоёр зуун) төгрөгөөр байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах:", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.-д “, зах зээлийн үнээс өндөр үнэтэй, эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Стандарт, хэмжил зүйн газрын албан хаагчдын бие бялдрын хөгжлийг дэмжих арга хэмжээ"-г зохион байгуулж, байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга /Л.Батбаяр/, ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | А.ЦОГБАЯР |
| АХЛАХ АУДИТОР | Ж.БҮЖИНХАНД |
| АУДИТОР | С.БОЛОРТУЯА |

*Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 44/A0171320 Улаанбаатар хот

САГ-2026/203/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт 72,760,000.00 (далан хоёр сая долоон зуун жаран мянган) төгрөгийн авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй, оны эцэст авлагатай гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.." , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт 72,760,000 (далан хоёр сая долоон зуун жаран мянган) төгрөгийн авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй, зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ний-н өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга /Л.Батбаяр/, ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР
АХЛАХ АУДИТОР Ж.БУЖИНХАНД
АУДИТОР С.БОЛОРТУЯА

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 45/А0171320 Улаанбаатар хот

САГ-2026/203/НА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гадаад томилолтын зардалд 21,173,300.00 (хорин нэгэн сая нэг зуун далан гурван мянга гурван зуун) төгрөг, Олон улсын чуулга уулзалтын бүртгэлийн хураамжид 10,400,000.00 (арван сая дөрвөн зуун мянган) төгрөг, дотоод албан томилолтын зардалд 2,970,000.00 (хоёр сая есөн зуун далан мянган) төгрөг, нийт 34,943,900.00 (гучин дөрвөн сая есөн зуун дөчин гурван мянга есөн зуун) төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулж, санхүүгийн тайлангаар өр төлбөртэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэнд;" "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулдаг, өр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга /Л.Батбаяр/, ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | А.ЦОГБАЯР |
| АХЛАХ АУДИТОР | Ж.БУЖИНХАНД |
| АУДИТОР | С.БОЛОРТУЯА |

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-1.Docx

1526190115

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 46/A0171320 Улаанбаатар хот

САГ - 2026/203/ИА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,863,848,200.00 (хоёр тэрбум найман зуун жаран гурван сая найман зуун дөчин найман мянга хоёр зуун) төгрөгийн барилгын их засварын ажлыг хүлээн авсан ч Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, газрын даргын тушаал гараагүй тул хөрөнгийг капиталжуулж бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", 14 дүгээр зүйлийн 14.4.-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,863,848,200 (хоёр тэрбум найман зуун жаран гурван мянга найман зуун дөчин найман мянга хоёр зуун) төгрөгийн барилгын их засварыг ажлыг хүлээн авсан ч капиталжуулж бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга (Л.Батбаяр), ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | А.ЦОГБАЯР |
| АХЛАХ АУДИТОР | Ж.БҮЖИНХАНД |
| АУДИТОР | С.БОЛОРТУЯА |

9006109
ATA16007
9025081411

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-1.Docx

1526180117

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 47/А0171320 Улаанбаатар хот

САГ - 2026/203/НА - СТА - ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байрны харуул, хамгаалалтын зардалд 71,751,000.00 (далан нэгэн сая долоон зуун тавин нэгэн мянган) төгрөгийн ажил үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант хугацаанд байрны харуул, хамгаалалтын ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга (Л.Батбаяр), ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | А.ЦОГБАЯР |
| АХЛАХ АУДИТОР | Ж.БҮЖИНХАНД |
| АУДИТОР | С.БОЛОРТУЯА |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-1.Docx

1526180119

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 48/А0171320 Улаанбаатар хот

САГ - 2026/203/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд байршуулбал зохих дараах мэдээллүүдийг хугацаа хоцруулж байршуулсан. Үүнд: Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл– Хөтөлбөр, зориулалт- 1 удаа, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт эдийн засгийн ангилал 1 удаа, байгууллагын батлагдсан орон тоонд орсон нэмэлт өөрчлөлт 1 удаа, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 1 удаа, орлогын 5 сая төгрөгөөс дээш гүйлгээний нийт 14,048,600.00 (арван дөрвөн сая дөчин найман мянга зургаан зуун) төгрөгийн 1 мэдээлэл, зарлагын нийт 170,033,900.00 (нэг зуун далан сая гучин гурван мянга есөн зуун) төгрөгийн 4 мэдээлэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогт 4.2.1.11-т хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд байршуулбал зохих зарим мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга (С.Батбаатар), санхүү албаны дарга (Л.Батбаяр)/, ахлах нягтлан бодогч, (Н.Долгормаа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

АХЛАХ АУДИТОР Ж.БУЖИНХАНД

АУДИТОР С.БОЛОРТУЯА